| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 5,145,903,300.00 | 4,361,930,649.46 | (783,972,650.54) | 84.8 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 5,145,903,300.00 | 4,361,930,649.46 | (783,972,650.54) | 84.8 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 10,032,800.00 | 14,876,875.00 | 4,844,075.00 | 148.3 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,260,000.00 | - | (2,260,000.00) | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,772,800.00 | 14,876,875.00 | 7,104,075.00 | 191.4 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | - | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 76 | 69 | (7) | 86.8 |
| **620001** | **Удирдах ажилтан** | 1 | 1 | - | 100.0 |
| **620002** | **Гүйцэтгэх ажилтан** | 51 | 45 | (6) | 82.4 |
| **620003** | **Үйлчлэх ажилтан** | 24 | 23 | (1) | 95.8 |

XTO5430809022899

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **405,388,745.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **405,388,745.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **405,388,745.10** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **280,470,281.40** |
| 210102 | Нэмэгдэл | 280,470,281.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **35,199,775.70** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,113,029.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,757,471.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,506,435.74 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,302,646.66 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,520,192.49 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,703,820.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,703,820.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **88,014,868.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 88,014,868.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **405,388,745.10** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **405,388,745.10** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,739,718.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 399,649,027.10 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагуудыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах чиг үүргийн хүрээнд "Хүн амын эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх" эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЭМГ-ын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталсан бөгөөд нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт ЭМГ-ын даргын А/214 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 226,202.7 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 6,335.5 | 6,335.5 |
| Авлага | 1,472.6 | - | (1,472.6) |
| Бараа материал | 603,948.5 | 471,718.1 | (132,230.4) |
| Үндсэн хөрөнгө | 2,906,305.5 | 2,807,470.3 | (98,835.2) |
| **Нийт хөрөнгө** | **3,511,726.6** | **3,285,523.9** | **(226,202.7)** |
| Өр төлбөр | 7,990.2 | - | (7,990.2) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,503,736.4 | 3,285,523.9 | (218,212.5) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3,511,726.6** | **3,285,523.9** | **(226,202.7)** |

Мөнгөн хөрөнгийн 6,335.5 мянган төгрөгийн үлдэгдэл нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Өмнөх оны “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн зарцуулагдаагүй үлдэгдлийг нэмэлт санхүүжилтийн авлагаар бүртгэснийг тайлант онд хүлээн авч, зарцуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 132,230.4 мянган төгрөгөөр буурахад өөрийн хөрөнгөөр 328,394.0 мянган төгрөгийн материал худалдан авсан, ХӨСҮТ-ээс хандиваар 454,990.0 мянган төгрөгийн товлолын вакцин, тариур, ЭМЯ болон НҮБ, ЗӨСҮТ-өөс 180,726.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, 606,687.2 мянган төгрөгийн материалыг зарцуулсан, 340,257.8 мянган төгрөгийн материалыг бусад эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлсэн, ЭМГ-ын даргын 2024 оны А/210 тоот тушаалаар 149,396.0 мянган төгрөгийн материалыг акталсан нь нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдэлд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, аж ахуйн материал нь голлох үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө данс буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 114,027.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ЭМГ-ын даргын 2024 оны 207 дугаар тушаалаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 8,841.3 мянган төгрөгийн хөрөнгийг 2,354.0 мянган төгрөгөөр дахин үнэлсэн, аймгийн ОНӨГ-ын даргын 2024 оны А/34 тушаалаар 20,607.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлсэн, ЭМГ-ын даргын 2024 оны А/212 дугаар тушаалаар 66,185.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан, 201,146.5 мянган төгрөгийн элэгдэл тооцсон зэргээс шалтгаалжээ.

Тайлант онд өр төлбөрийн данс 7,990.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны тэтгэвэрт гарсан албан хаагчийн тэтгэмж болон “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт зарцуулснаас үүссэн өглөгийг тайлант онд барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо данс тайлант оны үр дүнгээс шалтгаалж, 218,212.5 мянган төгрөгөөр буурчээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 4,854,866.7 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг дээд шатны төсвийн захирагч 38,769.4 мянган

төгрөгөөр нэмэгдүүлэн 4,893,636.1 мянган төгрөгөөр баталсан нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 262,300.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 5,155,936.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс болон жилийн эцсийн мөнгөн урамшуулалтай холбоотойгоор цалингийн зардлыг 51,800.0 мянган төгрөг, эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зориулалтаар 5 автомашин худалдан авахад зориулан 125,000.0 мянган төгрөг, ЭМГ-ын үүдний өргөтгөлийн засварт 80,000.0 мянган төгрөг, бусад зардлыг 5,500.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх 5,145,903.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 10,032.8 мянган төгрөгийн өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,584,079.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 14,876.9 мянган төгрөгийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,376,807.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 222,148.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,376,807.5 мянган төгрөг буюу 84.9 хувьтай байгаа нь 8 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 132,398.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарах албан хаагчид гараагүйгээс нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлын 634,627.3 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **71603- Эрүүл мэндийн бодлого, удирдлага** | **5,155,936.1** | **4,376,807.5** | **(779,128.6)** | **84.9** |
| 1.1 | 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,807,107.7 | 2,663,013.0 | (144,094.7) | 94.9 |
| 1.2 | 80219- Харуул хамгаалалтын зардал | 25,352.8 | 25,267.8 | (85.0) | 99.7 |
| 1.3 | 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал , дэмжлэг | 2,302,742.2 | 1,667,803.2 | (634,939.0) | 72.4 |
| 1.4 | 83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал | 20,733.4 | 20,723.5 | (9.9) | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэгдсэн судалгааны дүнгээр тайлант онд 4,505,091.8 мянган төгрөгийн 2 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтаар, 177,606.2 мянган төгрөгийн 4 ТАХ-г харьцуулалтын аргаар, 39,091.5 мянган төгрөгийн 3 ТАХ-г шууд худалдан авалтаар, нийт 4,731,789.5 мянган төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг зохион байгуулж, цахим системд үр дүнг тайлагнасан байна.

Тус газар батлагдсан төсвөөс Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын сангийн харилцах дансанд 11,545.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Мөн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардалд 71,523.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 56,591.7 мянган төгрөг төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 5,155,936.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 51,559.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дээд шатны төсвийн захирагч 2024 оны гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож, төсвийн хүрээнд зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 25,448.2 мянган төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 3,349.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 22,098.5 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг тулган шалгахад мөнгөн шагналыг цалингийн зардлаас гаргахгүй байх зөвлөмжийг хэрэгжээгүйгээс биелэлт 80 хувьтай байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 3 | 3,349.7 | 3 | 3,349.7 | 100.0 |
| Зөвлөмж | 4 | 22,098.5 | 3 | 13,342.2 | 60.0 |
| **Нийт дүн** | **7** | **25,448.2** | **6** | **16,691.9** | **80.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47,601.9 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрснээс, 42,277.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5,324.3 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

Байгууллагын 68 албан хаагчид 42,277.6 мянган төгрөгийн орон нутагт ажилласны нэмэгдэл хэлсийг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын 2 дахь заалт, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

### 5.2 Албан шаардлага

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд 19 албан хаагчид 5,324.3 мянган төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4 дахь заалт, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Байгууллагын 68 албан хаагчид 42,277.6 мянган төгрөгийн орон нутагт ажилласны нэмэгдэл хөлсийг давхардуулан олгосон | 1 | 42,277.6 | 1 | 42,277.6 | - | - | - | - | - | - | - | - |
| Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд 19 албан хаагчид 5,324.3 мянган төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн зардлаас олгосон | 1 | 5,324.3 | - | - | 1 | 5,324.3 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **47,601.9** | 1 | 42,277.6 | 1 | 5,324.3 | - | - | - | - | - | - |

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 он 02 сар 25 өдөр Дугаар ______ Дархан сум

01/18 Д0970288 - ДАА 2025/(39)/ИА СТА-ПМЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд 19 албан хаагчид 5,324,250.00 төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2-т Төрийн албан хаагчийн цалин хөлс нь: "*Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс*", 57.2.4-т "*үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ*" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*" журмын 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, .........." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Мөнгөн шагналыг цалингийн зардлаас гаргах зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Эрдэнэтулга, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ш.МӨНХБАЯР |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | У.БАТСҮРЭН |
| АХЛАХ АУДИТОР | С.БАТЦЭЦЭГ |
| АУДИТОР | Н.ОТГОНЦЭЦЭГ |

452504060

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар ______ Дархан сум

01/24-10170288-ДАА 2025/39/НА-СТА-ТШЗ.

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тус байгууллагын 68 албан хаагчид 42,277,580.00 төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2.1-т "*Орон нутагт ажилласны нэмэгдлийг …. аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "*Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү олгосон 42,277,580.00 /Дөчин хоёр сая хоёр зуун далан долоон мянга таван зуун наян/ төгрөгийг хавсралтад дурдсан албан хаагчдаар төлүүлж, Төрийн сан банкин дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг газрын дарга Б.Эрдэнэтулга, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

| | |
|---|---|
| ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ш.МӨНХБАЯР |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | У.БАТСҮРЭН |
| АХЛАХ АУДИТОР | С.БАТЦЭЦЭГ |
| АУДИТОР | Н.ОТГОНЦЭЦЭГ |

152505039

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны ...02 дугаар сарын ...25 –ны өдрийн 01/24 дугаар төлбөрийн актын хавсралт

| № | Овог | Нэр | Ажил мэргэжил | Нийт |
|---|---|---|---|---|
| 1 | Батсэргэлэн | Алтантулга | Байцаагч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй | 792,872.73 |
| 2 | Дорж | Алтанцэцэг | Сувилагч, арга зүйч | 514,451.68 |
| 3 | Алзахгүй | Ариунжаргал | Сувилагч, чих, хамар хоолойн сувилахуй | 741,040.19 |
| 4 | Лувсанчүлтэм | Ариунжаргал | Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн | 635,238.10 |
| 5 | Дамчаа | Бат-очир | Эрүүл мэндийн ажилтан, эрүүл мэндийн дэмжигч | 515,454.55 |
| 6 | Буяннэмэх | Батцэнгэл | Захирал, гүйцэтгэх захирал, эрүүл мэнд | 920,476.19 |
| 7 | Жамбалсүрэн | Баярзаяа | Бичиг хэргийн ажилтан | 630,381.82 |
| 8 | Эрдэнэцогт | Баярцогт | Эрүүл мэндийн ажилтан, эрүүл мэндийн дэмжигч | 713,645.93 |
| 9 | Батхүлэг | Болднасан | Нягтлан бодогч, төсвийн | 650,157.89 |
| 10 | Чимид | Болормаа | Эрүүл мэндийн ажилтан, эрүүл мэндийн дэмжигч | 488,571.43 |
| 11 | Болдбаатар | Бямбадорж | Эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан | 862,312.92 |
| 12 | Норслой | Ган | Жолооч | 103,923.81 |
| 13 | Мягмар | Ганцэцэг | Хүний их эмч | 938,638.10 |
| 14 | Хэрлэн | Гүрсанжид | Жолооч | 793,600.00 |
| 15 | Балдандорж | Гэрэлмаа | Хүний их эмч, цус судлалын | 613,737.80 |
| 16 | Цог-эрдэнэ | Гэрэлт-од | Программ хангамжийн инженер | 748,118.66 |
| 17 | Рэвгийлхам | Дамбийбалжир | Сантехникч, барилгын | 510,171.43 |
| 18 | Халзан | Дуламсүрэн | Эрүүл мэндийн ажилтан, эрүүл мэндийн дэмжигч | 720,000.00 |
| 19 | Цэнд-очир | Дунгармаа | Сувилагч, арга зүйч | 1,025,693.86 |
| 20 | Нямжав | Дэлгэрмаа | Нярав, кассын | 654,615.31 |
| 21 | Баатар | Дэлгэрсайхан | | 242,000.00 |
| 22 | Баатар | Жаргалмаа | Хүний нөөцийн мэргэжилтэн | 726,000.00 |
| 23 | Бажиг | Золбаясах | Эрүүл мэндийн байгууллагын бусад нэгжийн дарга | 901,655.50 |
| 24 | Дагийсүрэн | Золжаргал | Сувилагч, арга зүйч | 781,342.86 |
| 25 | Мөнхбат | Ихэрбаяр | Мэргэжилтэн, хэвлэл мэдээллийн | 759,609.57 |
| 26 | Цэцэгмаа | Монхоо | Цахилгаанчин | 469,894.74 |
| 27 | Моонон | Мөнхбаатар | Эрүүл мэндийн байгууллагын бусад нэгжийн дарга | 851,733.33 |
| 28 | Бадрах | Мөнхзул | Чанарын үнэлгээ, дотоод хяналт хариуцсан ажилтан | 858,000.00 |
| 29 | Баяндалай | Мөнхзул | Статистикч, эрүүл мэндийн | 573,157.89 |
| 30 | Оюунгэрэл | Мөнхтулга | Хүний их эмч | 1,161,600.00 |
| 31 | Чулуунбат | Мөнхцэцэг | Хүний их эмч | 606,157.89 |
| 32 | Равжаа | Мягмардарь | Эм зүйч, эмийн шинжилгээ судлалын /эмийн химич/ | 628,047.62 |
| 33 | Цогтбаатар | Нандинцэцэг | Сувилагч, дархлаажуулалтын сувилахуйн | 824,654.55 |
| 34 | Авирмэд | Наранцэцэг | Хүний их эмч | 882,600.00 |
| 35 | Дорж | Наранцэцэг | Эрүүл мэндийн байгууллагын бусад нэгжийн дарга | 872,619.13 |
| 36 | Батзориг | Одонтунгалаг | Хүний их эмч | 882,600.00 |
| 37 | Ядам | Отгонзаяа | Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн | 691,254.55 |
| 38 | Цэвээн | Оюунцэцэг | Сувилагч, арга зүйч | 635,238.10 |
| 39 | Дэмбэрэл | Оюунцэцэг | Үйлчлэгч | 137,142.86 |
| 40 | Лувсаншарав | Өлзийжаргал | Хүний их эмч | 924,628.57 |
| 41 | Бат-орших | Сарнайцэцэг | Нийгмийн эрүүл мэндийн төвийн захирал/дарга | 451,591.86 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 42 | Суурь | Сугармаа | Сувилагч, арга зүйч | 654,872.73 |
| 43 | Бямбаа | Төгсөө | Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн | 583,000.00 |
| 44 | Дэдэнжид | Туул | Хүний их эмч, зүрх судасны мэс засал судлал | 882,600.00 |
| 45 | Баянжаргал | Тэмүүжин | Хүний их эмч | 808,971.43 |
| 46 | Нямжанцан | Ундраа | Үйлчлэгч | 388,421.05 |
| 47 | Жаргалсайхан | Урангоо | Эм зүйч | 716,157.89 |
| 48 | Хурц | Уранчимэг | Нягтлан бодогч, төсвийн | 726,794.25 |
| 49 | Цэрэнсодном | Хандаа | Сувилагч, арга зүйч | 724,171.43 |
| 50 | Очир | Хишигсүрэн | Сувилагч, арга зүйч | 726,000.00 |
| 51 | Түмэн-өлзий | Хулан | Хүний их эмч | 140,095.24 |
| 52 | Бадам | Хулан | Хүний нөөцийн туслах | 192,609.52 |
| 53 | Баасандорж | Цэрмаа | Хүний их эмч, эмнэл зүйн хоол эмчилгээ судлал | 756,514.29 |
| 54 | Базаррагчаа | Шүрээ | Эрүүл мэндийн ажилтан, эрүүл мэндийн дэмжигч | 490,909.09 |
| 55 | Пүрэвжав | Энхзул | Хүний их эмч | 588,400.00 |
| 56 | Ганболд | Эрдэм | Хүний их эмч | 776,947.37 |
| 57 | Бат | Эрдэнэбилэг | Сувилагч, арга зүйч | 968,905.26 |
| 58 | Ноябрь | Эрдэнэбилэг | Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн | 575,088.04 |
| 59 | Буяндалай | Эрдэнэтулга | Захирал, гүйцэтгэх захирал, эрүүл мэнд | 676,307.77 |
| 60 | Одхүү | Эрдэнэхүү | Сувилагч, арга зүйч | 996,989.47 |
| 61 | Бямба | Эрдэнэчимэг | Байцаагч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй | 723,927.27 |
| 62 | Батнасан | Эрдэнэчимэг | Эрүүл мэндийн байгууллагын бусад нэгжийн дарга | 745,266.48 |
| **Нийт дүн** | | | | **42,277,580.00** |